

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСЫН

ЭКСПОРТ-ИМПОРТЫН БАНК  
ХООРОНДЫН

ӨДРИЙН

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Сангийн яам  
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ .....

2025 оны 1 сарын 6 одор

Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

**ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР  
БАРИХ ТӨСЛИЙН**

**ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Сангийн яам  
АДВАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ .....  
2025 онд 1 сарын 6-ны өдөр  
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

## ГАРЧИГ

### **Зүйлүүд**

1.	Тодорхойлолт:	1
2.	Зээлийн дүн:	4
3.	Зээлээр санхүүжүүлэх эрх бүхий гэрээ:	5
4.	Зээлийн зарцуулалт:	7
5.	Зээлийн хүү:	9
6.	Эргэн төлөлт:	9
7.	Төлбөр (үүд)	9
8.	Дефолтын хүү:	10
9.	Урьдчилсан нөхцөл:	10
10.	Аюулгүй байдал:	11
11.	Амлалт:	12
12.	Авлигын эсрэг хууль:	12
13.	Ил тод, шударга байдал:	13
14.	Зээлийн хэлэлцээрийн бүрэлдэхүүн хэсэг болох Ерөнхий нөхцөл:	13

### ХАВСРАЛТ

Ерөнхий нөхцөлүүд:	14
--------------------	----

Хавсралт I. Гэрээ батлах маягт:	29
Хавсралт II. Зээлдэгчийн хуулчийн хууль зүйн дүгнэлтийн загвар:	30
Хавсралт III. Төлбөрийн зөвшөөрлийн маягт:	32
Хавсралт IV. Эргэн төлөлтийн хуваарь:	33
Хавсралт V. Гарын үсэг зурах эрх олгох маягтын загвар:	35

Монгол Улсын Сангийн яам  
АЛБАН ёСНЫ ӨРЧҮҮЛГА МЭР

Гарын үсэг /Signature/ .....  
20~~25~~ оны / 1 / сарын 6 / эдер  
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

ЭНЭХҮҮ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ 2025 оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр

Нэг талаас МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ төлөөлж \_\_\_\_\_  
(цаашид “Зээлдэгч” гэх ба хэрэв тухайн агуулгад өөрөөр заагаагүй бол түүний  
залгамжлагч буюу эрх, үүргийг шилжүүлэн авахаар зөвшөөрөгдсөн этгээдийг),

#### МӨН

Нөгөө талаас 1981 оны Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын  
Банкны тухай хууль (Энэтхэг Улсын Парламентаар баталсан)-иар  
байгуулагдсан корпорац, төв нь Энэтхэг Улсын Мумбай хотын 400 005, Куфе  
Парад дахь Дэлхий худалдааны төв цогцолборын 1-р Төв байрны 21 давхарт  
байрлах, **БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСЫН ЭКСПОРТ-ИМПОРТЫН  
БАНК** (цаашид “ЭНЭТХЭГ УЛСЫН ЭКСИМ банк” гэх ба хэрэв тухайн агуулгад  
өөрөөр заагаагүй бол түүний залгамжлагч буюу эрх, үүргийг шилжүүлэн  
авахаар зөвшөөрөгдсөн этгээдийг) байгуулав.

#### ГЭРЭЭГЭЭР:

ЭКСИМ банкнаас зээлдэгчид нийт 700,000,000 ам.доллар (зөвхөн долоон зуун  
сая ам.доллар) хүртэлх хэмжээний зээлийг Зээлдэгч улсын нутаг дэвсгэрт  
байгуулж буй Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг санхүүжүүлэх  
зорилгоор Зээлдэгчид олгохоор харилцан тохиролцов.

ЭКСИМ банкнаас 2019 оны 10 дугаар сарын 9-ний өдөр Зээлдэгч болон  
ЭКСИМ банк хооронд байгуулсан Зээлийн хэлэлцээрийн хүрээнд Зээлдэгчид  
236,000,000 ам.доллар (зөвхөн хоёр зуун гучин зургаан сая ам.доллар) хүртэлх  
хэмжээний зээлийг олгохоор тохирсон. Дээр дурдсан зээлийн эх үүсвэрийг  
бүхлээр нь энэ өдөр хүртэл ашиглаагүй байгаа тул энэхүү 700,000,000  
ам.долларын Хэлэлцээрт гарын үсэг зурснаар энэхүү 236,000,000  
ам.долларын зээлийн эх үүсвэрийг хаасанд тооцно.

Иймээс, ЭКСИМ банк болон Зээлдэгч дараах асуудлаар **ХАРИЛЦАН  
ТОХИРОЛЦОВ**. Үүнд:

#### 1. Тодорхойлолт:

Энэхүү Хэлэлцээр болон Хавсралтад дурдсан дараах нэр томъёо нь тухайн  
агуулгад өөрөөр заагаагүй тохиолдолд дор дурдсан утгыг илэрхийлнэ. Үүнд:

“Урьдчилгаа” гэж энэхүү Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд заасны дагуу Зээлийн  
зарцуулалт бүрийн, эсхүл тухайн агуулгаас хамааран үндсэн зээлийн  
төлөгдөөгүй дүнг;

“Ажлын өдөр” гэж Хэлэлцээрт заасан зорилгын дагуу Мумбай, Улаанбаатар, Нью Йорк болон Лондон хот дахь ЭКСИМ банк болон (тухайн тохиолдлоос хамааран) банкнуудын үйл ажиллагаа явуулах аливаа өдрийг;

“Худалдан авагч” гэж Эрх бүхий гэрээний дагуу Зээлдэгч улс дахь худалдан авагчийг;

“Иж бүрэн засвар үйлчилгээний гэрээ” гэж Зээлдэгч нь Худалдагчтай Төсөл дууссаны дараа иж бүрэн засвар үйлчилгээ хийхээр байгуулсан 3-5 жилийн хугацаатай гэрээ;

“Зээл” гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан зээлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн, мөн тухайн агуулгаас хамаарч тухайн үеийн үндсэн зээлийн төлөгдөөгүй дүнг;

“Төслийн нарийвчилсан тайлан” буюу “ТНТ” гэж Энэтхэг Улсын Засгийн газраас баталсан журмын дагуу бэлтгэгдсэн Зээл олгох эрх олгоход ашиглах нарийвчилсан тайланг, Гэсэн хэдий ч Зээлийн 1 (нэг)-хүртэлх хувийг ТНТ-г бэлтгэхэд зарцуулна;

“Доллар” болон “\$” тэмдэглэгээ нь Америкийн Нэгдсэн Улсын хууль ёсны мөнгөн тэмдэгтийг;

“Зээлийн хүчин төгөлдөр болох өдөр” гэж 9.1 дэх хэсэгт заасны дагуу Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрийг;

“Эрх бүхий гэрээ” гэж энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасны дагуу зээлийн хөрөнгөөс санхүүжих эрх бүхий гэрээг;

“Эрх бүхий бараа, үйлчилгээ” гэж Эрх бүхий гэрээний хүрээнд санхүүжүүлж буй Зээлдэгч болон Энэтхэг Улсын Засгийн газрын хооронд тохиролцсон Зээлдэгчийн улсад хэрэгжүүлэх төслийн бараа үйлчилгээ болон зөвлөх үйлчилгээг хэлнэ. Эрх бүхий гэрээний дагуу гэрээний нийт бараа үйлчилгээний 75%/65%/50%-ийг (тохирох дүнг ашиглана) Энэтхэг Улсын Худалдагч нийлүүлэх бөгөөд үлдэх 25%/35%/50%-тай (тохирох дүнг ашиглана) тэнцэх бараа, үйлчилгээг Худалдагч эрх бүхий гэрээний дагуу Энэтхэг Улсаас бусад улсаас худалдан авч хангаж болно;

“Эрх бүхий үнэ” гэж Эрх бүхий гэрээний дагуу FOB (хөлгийн тавцан хүртэл төлөгдсөн)/CFR (өртөг, зардал, тээвэр)/CIF (өртөг, зардал, даатгал, тээвэр)/CIP (тээврийн хэлс, даатгал төлөгдсөн) нөхцөлөөр 100% (нэг зуун хувь) төлөх, ЭКСИМ банкаас Зээлийн эх үүсвэрээс Зээлдэгчид олгох гэрээний дүнг;

**“Төлбөрийн зөрчил үүсэх нөхцөл байдал”** гэж Ерөнхий нөхцөлийн К.1 хэсэгт заасан аливаа тохиолдлыг, эсхүл мэдэгдэл өгснөөр, хугацаа өнгөрснөөр болон/эсхүл бусад шаардлагыг биелүүлснээс шалтгаалсан дээрх хэсэгт дурдсан тохиолдолд тооцогдох нөхцөлийг;

**“FOB/CFR/CIF/CIP”** гэж Инкотермс 2020-д тодорхойлсон далайн тээврийн нөхцөлүүдийг;

**“Ерөнхий нөхцөлүүд”** гэж энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг бөгөөд энд ишлэн оруулсан Хавсралтад заасан нөхцөл, болзол, дүрэм, журам болон бусад заалтыг;

**“Энэтхэг Улсын контент”** гэдэг нь Эрх бүхий бараа, үйлчилгээний хүрээнд буюу түүний гэрээлсэн үнийн дүнгийн хүрээнд Энэтхэг Улсаас нийлүүлсэн бүрэлдэхүүн хэсгийг хэлнэ. Эрх бүхий бараа, үйлчилгээний хамгийн багадаа 75%/65%/50%-ийг (тохирох дүнг ашиглана) Энэтхэг Улсаас авах ёстой бөгөөд худалдан авалт нь Энэтхэг Улсын Засгийн газраас гаргадаг заавар, журмын дагуу байна;

**“Хүү төлөх өдөр”** гэж энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараагаар ЭКСИМ банкнаас заасан Хэлэлцээрийн дагуу тооцох хүү, бусад төлбөрийг Зээлдэгч төлбөл зохих хуанлийн жилийн хоёр өдрийг;

**“Хүү төлөх хугацаа”** гэж тухайн тохиолдлоос хамааран Урьдчилгаа, эсхүл Зээлтэй холбогдуулан Ерөнхий нөхцөлүүдийн С хэсэгт заасан хугацааг;

**“Хүү”** гэж тухайн тохиолдлоос хамааран Урьдчилгаа, эсхүл Зээлийн төлөгдөөгүй дунд ЭКСИМ банкнаас ногдуулах жилийн нэг зууны далан таван хувийн (1.75%) хүүг;

**“Гүйлгээ хийх банк”** гэж энэхүү Хэлэлцээрийн 3.1(c) заалтад заасан аккредитив нээх эрх бүхий банкийг;

**“Зээлдүүлэгчийн инженер”** гэж ЭКСИМ банкнаас томилсон бие даасан инженер/агентлаг байх бөгөөд Эрх бүхий гэрээ/Төслийн хэрэгжилтийн аль ч үе шат/ Эрх бүхий гэрээний хэрэгжилт/ Төсөлд үнэлгээ хийнэ;

**“Хэлэлцээ хийх банк”** гэж ЭКСИМ банкийг хэлнэ. Худалдагч аккредитивын хүрээнд хийх хэлэлцээний баримт бичгүүдийг ЭКСИМ банканд хүргүүлэх ба ЭКСИМ банк нь Худалдагчид Эрх бүхий гэрээний төлбөрийг шилжүүлнэ;

**“Төлбөрийн зөвшөөрөл”** гэж 4 дүгээр заалтын дагуу Зээлдэгчээс ЭКСИМ банканд Эрх бүхий гэрээний дагуу урьдчилгаа төлбөр хийх, эсхүл Зээлдэгчийн улсад үзүүлсэн үйлчилгээний хөлсөнд Худалдагчийн дансанд зохих төлбөрийг шилжүүлэх эрхийг олгосон зөвшөөрлийг;

**“Дефолтод орж болзошгүй нөхцөл байдал”** гэж Ерөнхий нөхцөлийн К.1-т заасан нөхцөл байдал үүсэх болон үүсэж болзошгүй нөхцөл байдалд орж цаг хугацаа өнгөрсөн, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа дууссан эсхүл/мөн мэдэгдэл хүргүүлснээр Дефолтод орох нөхцөл байдлыг;

**“Төсөл”** гэж ЭКСИМ банкнаас Зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхийг зөвшөөрсөн төсөл болох Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөлтэй холбоотой болон түүнд хамааралтай бараа, үйлчилгээг хэлэх ба Зээлдэгч болон ЭКСИМ банк хооронд харилцан тохиролцсоны дагуу орох аливаа агуулгын өөрчлөлтүүдийг;

**“Төслийн Эрх бүхий байгууллага”** гэж Монгол Улсын хуульд зааснаар төслийг барилгын болон өдөр тутмын үйл ажиллагааг хариуцаж буй этгээдийг хэлнэ;

**“Төслийн менежментийн зөвлөх” эсхүл “ТМЗ”** гэж тендерийн баримт бичиг/ ТНТ-г бэлтгэх, бараа бүтээгдэхүүн худалдан авах, төслийн удирдлага, хэрэгжилтэд хяналт тавих (нэхэмжлэх, Энэтхэг Улсын контентыг баталгаажуулах) үйл ажиллагааны үнэлгээ хийх зорилгоор Зээлдэгчээс томилогдсон Энэтхэг Улсын зөвлөхийг хэлнэ. Төслийн засвар үйлчилгээ, ашиглалтад оруулсны дараах үе шатууд, тухайлбал, хөрөнгийн чанар болон зээлдэгчийн улсын тогтоосон бусад хэрэгцээг баталгаажуулах, Төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх бусад үйл ажиллагаа;

**“Эргэн төлөх өдөр”** гэж Зээлийн хэсэг бүрийг эргэн төлөх өдрийг;

**“Худалдагч”** гэж Эрх бүхий гэрээний хүрээнд томилсон Энэтхэг Улсын худалдагчийг мөн ТМЗ-г;

**“Тээвэрлэлт”** гэж Худалдагч болон Худалдан авагч харилцан тохиролцсон далаин, эсхүл бусад төрлийн тээвэрлэлтийг;

**“Зарцуулалтын сүүлийн өдөр”** гэж Төслийн үйл ажиллагаа төлөвлөсний дагуу дуусгавар болсон өдрөөс хойш 48 (дөчин найм)-н сарын хугацаа дууссаны дараах өдрийг хэлнэ.

## 2. Зээлийн дүн:

ЭКСИМ банк нь нийт 700,000,000 ам.доллар (зөвхөн долоон зуун сая ам.доллар)-ын Зээлийг Зээлдэгчид олгохоор зөвшөөрч, Зээлдэгч нь энэхүү зээлийг Эрх бүхий гэрээнүүд болон түүний Эрх бүхий дүнгээр Эрх бүхий бараа үйлчилгээг санхүүжүүлэх бөгөөд энэхүү Хэлэлцээрт заасан нөхцөл, журмын дагуу худалдан авахад ашиглахаар тогтов.



Гэсэн хэдий ч, Эрх бүхий гэрээ буюу Төслийн хүрээнд Эрх бүхий гэрээ хэрэгжиж дууссаны дараа ЭКСИМ банкны зүгээс болон бие даасан агентлагийн зүгээс Эрх бүхий гэрээнүүдийн хөгжилд үзүүлсэн нөлөөлөл болон тогтвортой байдлыг үнэлэхэд Зээлийн эх үүсвэрийн 0.5 (тэг зуны таван) хувиас хэтрэхгүй дунг ашиглах боломжтой. Цаашлаад 52,000,000 сая ам.доллар (зөвхөн тавин хоёр сая ам.доллар)-ын эх үүсвэрийг магадалшгүй зардал (үүнд Лицензийн төлбөр, катализатор болон химиийн бодис) гэж тооцох бөгөөд энэхүү эх үүсвэрийг ашиглахын тулд ЭКСИМ банк болон Энэтхэг Улсын Засгийн газрын зөвшөөрлөөр ашиглана.

**3. Зээлээр санхүүжүүлэх эрх бүхий гэрээ:**

3.1. Гэрээ дараах нөхцөлийг хангаагүй бол Зээлээр санхүүжихгүй. Үүнд:

- a) Гэрээг Зээлдэгчийн улсад эрх бүхий бараа, үйлчилгээг импортлох зорилгоор байгуулсан ба зөвлөх үйлчилгээ бүхий гэрээний хувьд зөвлөх үйлчилгээг Энэтхэг Улсаас авахаар заасан байх;
- b) Гэрээний үнийн дунг ам.доллароор илэрхийлэх ба 50,000 ам.доллар (тавин мянган ам.доллар)-оос багагүй байх эсхүл ЭКСИМ банк болон Зээлдэгч хооронд тухай бүр тохиролцсон үнийн дүн байх;
- c) Гэрээнд Худалдан авагч Худалдагчийн буцалтгүй аккредитивын дагуу үйлчилгээнээс бусад эрх бүхий бараа, төлбөрийг ачигдсан тоо хэмжээний дагуу 100% (зуун хувь) FOB CFR CIF CIP нөхцөлөөр төлөхөөр заасан байх;
- d) Зээлдэгч нь энэхүү Хэлэлцээрээр Эрх гэрээ нь Зээлдэгчийн газар нутагт ноогдох бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөх тухай нотолгоог ЭКСИМ банканд гаргана. Үүнд аж ахуйн нэгжийн орлогын, хувь хүний орлогын болон нэмэгдсэн өргтийн албан татвар, импортын/гаалийн албан татвар, онцгой албан татвар болон Зээлдэгчийн улсад гүйцэтгэх гэрээтэй холбоотойгоор Худалдагчийн хөлсөлсөн түр ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл орно;
- e) Зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан импортолсон тоног төхөөрөмж, машин механизм болон тээврийн хэрэгслийг төсөл дуусах хүртэл хугацаанд түр горимоор оруулахыг зөвшөөрнө. Энэхүү заалт нь Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд Талуудын байгуулсан бусад Зээлийн хэлэлцээрт хамаарна;
- f) Гэрээнд Зээлдэгч ЭКСИМ банканд Төлбөрийн зөвшөөрөл олгох тухай заасан байх бөгөөд Худалдагч нь ЭКСИМ банкнаас эрх бүхий бараа, үйлчилгээний хэмжээгээр зохих төлбөрийг нэхэмжлэх, эсхүл зарим тохиолдолд, урьдчилгаа төлбөрийг нэхэмжлэх;
- g) Гэрээнд Эрх бүхий бараа, Үйлчилгээг ачуулахаас өмнө Худалдан авагчийн нэрийн өмнөөс барааг шалгах, мөн

- Худалдагч энэхүү Хэлэлцээрийн (d) дэд хэсэгт заасан аккредитивын зохицуулалтын дагуу барааны баримт бичгүүдийг бүрдүүлэхдээ бараа шалгасан гэрчилгээг Хэлэлцээ хийх банканд мөн хүргүүлэх тухай заах;
- h) Түүнчлэн, гэрээнд энэхүү Хэлэлцээрийн дагуу зээлийн ашиглаагүй аливаа хэсгийг түдгэлзүүлсэн, эсхүл цуцалсны улмаас эрх бүхий барааг, эсхүл түүний хэсгийг санхүүжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Худалдан авагч, эсхүл Худалдагчийн өмнө ЭКСИМ банк хариуцлага хүлээхгүй тухай заах;
  - i) Зээлдэгч нь Хавсралт I-т заасан хэлбэрээр гэрээний талаарх товч мэдээлэл болон ЭКСИМ банкнаас шаардаж болох бусад баримт бичиг, мэдээллийг ЭКСИМ банканд хүргүүлсэн ба ЭКСИМ банк гэрээ нь эрх бүхий болохыг баталж, эрх бүхий үнийг тодорхой заасан зөвшөөрлийг бичгээр олгосон болно;
  - j) Гэрээ нь Төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгасан байна;
  - k) Энэхүү Хэлэлцээр байгуулагдсан өдрөөс хойш арван найман сарын дотор хамгийн багадаа нэг гэрээ байгуулагдсан байна, Гэсэн хэдий ч бүх гэрээ энэхүү Хэлэлцээр байгуулагдсан өдрөөс хойш 48 (дөчин найм) сарын дотор эцэслэгдсэн байх ёстой бөгөөд гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 48 (дөчин найм) сарын дотор аливаа санхүүжилт ашиглагдаагүй байвал тус ашиглагдаагүй дүн хүчингүй болно;
  - l) Хавсралт II-т туссан Хууль зүйн дүгнэлтийг Зээлдэгч ЭКСИМ банканд хүргүүлсэн байна;
  - m) Зээлдэгч Төсөл дуссаж, хүлээлгэн өгснөөс хойш 3-5 жилийн иж бүрэн засвар үйлчилгээний гэрээ байгуулсан байна; Гэсэн хэдий ч Зээлдэгч өөрийн хэрэгцээ/ бодлогын баримт бичигт заасны дагуу шаардлагатай бол орон нутгийн гүйцэтгэгчтэй тус гэрээг байгуулж болно. Ийм тохиолдолд тус гэрээний зардлыг Зээлдэгч хариуцна.
- 3.2 Эрх бүхий гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулахаар талууд тохирсон бол Зээлдэгч нь ЭКСИМ банканд оруулсан өөрчлөлтийн тухай дэлгэрэнгүй тайлбарыг тэдгээр өөрчлөлтийг Зээлдэгч зөвшөөрч баталсан тухай нотолгооны хамт хүргүүлнэ. Гэхдээ, хэрэв оруулж буй өөрчлөлт нь гэрээний цар хүрээ, агуулга болон нийт үнийн дүнд өөрчлөлт оруулахгүй буюу гагцхүү гэрээний дагуу нийлүүлэх Эрх бүхий бараа, үйлчилгээний техникийн үзүүлэлтийг өөрчлөх төдий байвал ЭКСИМ банк нь зөвшөөрөл олгох шаардлагагүй. Тийм боловч аливаа өөрчлөлт оруулах тохиолдолд Зээлдэгч нь ЭКСИМ банканд тэр тухай мэдэгдэнэ.

#### **4. Зээлийн зарцуулалт**

- 4.A Аккредитиваар худалдан авах эрх бүхий бараа, үйлчилгээ:
- 4.A.1 Хэлэлцээрийн 3.1(с) заалттай уялдуулан ЭКСИМ банк холбогдох гэрээг баталсны дараа Гүйлгээ хийх банк нь Зарцуулалтын сүүлчийн өдрөөс өмнө ЭКСИМ банктай зөвшилцэн бүх аккредитивын дансыг товлосон хугацааны дотор нээнэ. Аккредитивыг нээхдээ Хэлэлцээ хийх банктай зөвшилцнэ. Аккредитивыг Олон улсын худалдааны танхимаас гаргасан (Хэвлэл №.600) Баримтын аккредитивын нийтлэг журам, хэм хэмжээ (2007 онд шинэчилсэн)-ний дагуу нээх ба энэ нь буцаан үл дуудах аккредитив байна. Аккредитив тус бүр гэрээний үнэ, хэрэв шаардлагатай бол тээвэрлэлт/даатгалын төлбөрийг хамрах ба Худалдагч аккредитивд тодорхойлсон баримтууд, үзлэг шалгalt хийсэн тухай гэрчилгээ болон ТМЗ эсхүл Худалдан авагчаас гаргасан Энэтхэг Улсын контентын шаардлагад нийцэж байгаа тухай баталгааг бүрдүүлж өгснөөр төлбөрийг Худалдагчид шилжүүлнэ.
- 4.A.2 Худалдагчийн Хэлэлцээ хийх банканд өгсөн баримтууд нь бүрэн бөгөөд холбогдох аккредитивд нийцэж буй бол Хэлэлцээ хийх банк нь Худалдагчид төлбөрийг шилжүүлнэ. Төлбөрийн үнийн дүн нь холбогдох тээвэрлэлтийн үнээс урьдчилгаа төлбөр/хадгаламжийн мөнгийг хасаж тооцсон Эрх бүхий гэрээний үнийн дүнгийн зуун хувиас (100%) илүүгүй байх ба Хэлэлцээ хийх банкны арилжааны ханшаар тооцсонтой адил хэмжээний үнийн дүнг Худалдагчийн дансанд Хэлэлцээ хийх банк шилжүүлнэ.
- 4.A.3 ЭКСИМ банк нь Хэлэлцээ хийх банкны хувьд Заалт 4.A.2-д дурдсан ашиглалт нь Зээлдэгчид ЭКСИМ банкнаас олгох Зээлийн урьдчилгаанд тооцогдох бөгөөд ЭКСИМ банк Мумбайгаас Худалдагчид шилжүүлэгт хийсэн өдрийг Урьдчилгаа хийсэн өдөр гэнэ. ЭКСИМ банк Урьдчилгааны дүн болон өдрийг Зээлдэгчид мэдэгдэнэ. Зарцуулалт болон дансны гүйлгээтэй холбоотой ЭКСИМ банкны тайлан тооцоо эцсийн, илэрхий алдаагүй байх бөгөөд Зээлдэгчийн хувьд заавал мөрдөгдөх шинжтэй байна.
- 4.A.4 Зээлдэгчийн улсын гадна төлөгдөх банкны хураамж, зардал, шимтгэл, эсхүл тэмдэгтийн хураамжийг Худалдагч хариуцах бөгөөд Зээлдэгчийн улсын дотор төлөгдөх төлбөрийг Худалдан авагч хариуцна.
- 4.A.5 ЭКСИМ банк ямар ч нөхцөлд аккредитивыг ашиглах, эсхүл холбогдох баримт бичгийг шилжүүлэхтэй холбоотойгоор хийгдэх үйлдэл, эс үйлдэлд хариуцлага хүлээхгүй.

#### **4.B Төлбөрийн зөвшөөрлийн дагуу зарцуулалт хийх:**


- 4.B.1 Зээлдэгч нь:

Монгол Улсын Сангийн яам  
БАН ЕСНЫ ОРЧУУЛГА МЕН  
рын үсэг /Signature/ .....  
20 2016 оны 1 сарын 6 өдөр  
Улаанбаатар хот

- a) Эрх бүхий гэрээний дагуу урьдчилгаа төлбөрийн дүнг (энэхүү урьдчилгаа төлбөрийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр зөвшөөрсөн тохиолдолд) Худалдагчид урьдчилгаа төлбөрийг гаргах тухай Худалдан авагчийн хүсэлт хүлээн авсан, эсхүл
- b) Эрх бүхий гэрээний дагуу Худалдагчийн хийсэн хангамж, гүйцэтгэсэн ажил болон/эсвэл үзүүлсэн үйлчилгээний үнийн дүнг илэрхийлсэн, Энэтхэг Улсын контентын шаардлагыг хангасан гэх ТМЗ болон худалдан авагчийн баталгаатай Зээлдэгчээс ирүүлсэн нэхэмжлэх, авснаар,
- c) Эрх бүхий гэрээний дагуу барьцааны мөнгийг чөлөөлөх тухай хүсэлтийг Худалдагчаас Худалдан авагчид гаргах,

Худалдагчид эрх олгосон Төлбөрийн зөвшөөрлийг Хавсралт III-т заасан маягтын дагуу эрх бүхий гэрээнд үндэслэн эрх бүхий үнийн дүнтэй тэнцэх хэмжээнд гаргаж ЭКСИМ банканд хүргүүлнэ.

- 4.B.2 ЭКСИМ банк Зээлдэгчийн Төлбөрийн зөвшөөрлийг эх хувиар хүлээн авснаар заасан үнийн дүнг Худалдагчийн ЭКСИМ банканд урьдчилан мэдэгдсэн банкин дахь дансанд шилжүүлнэ.
- 4.B.3 Төлбөрийн зөвшөөрлийн дагуу дээр дурдсан Худалдагчийн дансанд ЭКСИМ банкны хийсэн шилжүүлэг нь ЭКСИМ банкнаас Зээлдэгчид өгөх Зээлийн урьдчилгаа болох ба ЭКСИМ банк Мумбайгаас Худалдагчийн дансанд уг төлбөрийг шилжүүлсэн буюу төлсөн өдрийг Урьдчилгаа хийсэн өдөр гэж үзнэ. ЭКСИМ банк Зээлдэгчид Урьдчилгаа хийсэн өдөр болон дүнг мэдэгдэнэ. Зээлдэгчийн данснаас хийгдсэн зарцуулалттай холбоотой ЭКСИМ банкны тайлан тооцоо эцсийн, илэрхий алдаагүй байх бөгөөд Зээлдэгчийн хувьд заавал мөрдөгдөх шинжтэй байна.
- 4.C Дээр дурдсанаас үл хамааран, зарцуулалтын сүүлчийн өдрөөс хойш Худалдагчид ямар нэг төлбөр хийх, эсхүл Зээлийн нийт дүнгээс хэтэрсэн дүнг төлөх үүргийг ЭКСИМ банк хүлээхгүй. Иймээс, Зээлдэгч Эрх бүхий гэрээг байгуулахдаа 4.A.1 заалтад заасан хугацаанд аккредитивыг нээх, эсхүл тухайн тохиолдолд Төлбөрийн зөвшөөрлийг ЭКСИМ банканд хүргүүлснээр ЭКСИМ банк уг зөвшөөрөл болон аккредитивын дагуу холбогдох зарцуулалтыг Төлбөр хийх сүүлийн өдрөөс өмнө хийх, Эрх бүхий гэрээний нийт эрх бүхий үнэ нь Зээлийн дүнгээс хэтрэхгүй байхыг хариуцна.
- 4.D Зээлийн хүрээнд хийгдсэн Урьдчилгаа төлбөр(үүд)-ийг татвар болон бусад холбогдох шимтгэлд ашиглахыг хориглоно.




## 5. Зээлийн хүү:

- 5.1 Зээлийн хүү төлөх өдөр Зээлдэгч Урьдчилгаа бүрд хуримтлагдсан хүү, эсхүл тухайн тохиолдолд Хүү төлөх хугацаанд Зээлийн үлдэгдэлд хуримтлагдсан хүүг ЭКСИМ банканд хүүгийн хэмжээгээр тооцож төлнэ.
- 5.2 Урьдчилгаа бүрийг хийсэн өдрөөс хүү хуримтлагдаж эхлэх ба нэг жилд 360 хоног байхаар бодож хүүг хугацаа хэтэрсэн бодит хоног (хүү хуримтлагдаж эхлэх эхний өдрийг оруулан)-т үндэслэн тооцно.
- 5.3 Энэхүү Хэлэлцээрийн дагуу төлөх хугацаа нь болсон боловч төлөхгүй байж болох бусад хүүг холбогдох Хүү төлөх өдөр зохих журмын дагуу төлнэ.
- 5.4 Дор дурдсан 8 дахь заалтад зааснаас үл хамааран урьдчилгаа болон Зээлийн үлдэгдэлд тооцсон бүх хүү, энэхүү Зээлийн Хэлэлцээрийн дагуу төлөх бусад хүүг зохих өдөр төлөөгүй бол тухайн өдрөөс эхлэн дээр дурдсан хүүгийн хэмжээгээр нэмэгдэл хүүг тооцох бөгөөд хагас жилд тутамд үлдэгдэл нийлмэл хүүг төлөхөд нэгтгэн төлнэ.

## 6. Эргэн төлөлт:

- 6.1 Зээлдэгч нь ЭКСИМ банканд үндсэн Зээлийн үлдэгдлийг Хэлэлцээрийн Хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа таван (5) жил өнгөрсний дараа хорин (20) жилээс дээшгүй хугацаа (зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацааг оролцуулан)-ны дотор хагас жил тутамд харилцан адил хэмжээтэйгээр эргэн төлөхийг зөвшөөрч, үүрэг хүлээж байна.
- 6.2 Энэхүү эргэн төлөлтийн хуваарь нь Хэлэлцээрийн Хавсралт IV-т заасан байна. ЭКСИМ банк нь Хэлэлцээрийн дагуу Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрийг болон Зээлийн эргэн төлөлтийн хуваарийг Зээлдэгчид албан бичгээр мэдэгдэнэ. Гэхдээ ямарваа шалтгаанаар ЭКСИМ банкнаас хийсэн Урьдчилгааны нийт эцсийн дүн нь энэхүү Хэлэлцээрийн дагуу Зээлдэгчид олгохоор тохирсон Зээлийн дүнгээс бага байвал дээр дурдсан эргэн төлөлтийн хүрээнд эргэн төлөлтийн дүнг хамгийн сүүлийн төлөлтүүдээс хасаж тооцно.

## 7. Төлбөр (үүд)



**7.1 Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд төлөх хүү:**

Зээлдэгч эрх бүхий гэрээ бүрээс зарцуулагдаагүй үлдсэн Зээлийн үлдэгдэлд жилийн 0.50% (тэг зууны тавин хувь)-иар тооцож ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд төлөх хүү (commitment fee)-г ЭКСИМ банканд төлнө. Уг хүүг ЭКСИМ банк холбогдох гэрээг баталсан өдрөөс хойш арван хоёр (2) сар өнгөрсний дараагаас тооцож эхлэх ба Эрх бүхий гэрээний Эрх бүхий үнийн дүнг эцэслэн зарцуулсан өдөр, эсхүл холбогдох Зарцуулалтын сүүлийн өдрийн аль өмнөх өдөр хүү зогсоно. Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд төлөх хүүг дээр дурдсан арван хоёр сарын хугацаа өнгөрсний дараа 5 дугаар заалтад заасан хагас жилийн хүүгийн хамт Хүү төлөх өдөр тухай бүр төлнө.

**7.2 Үйлчилгээний шимтгэл**

ЭКСИМ банк Эрх бүхий гэрээг баталсан өдрөөс хойш хүү төлөх өдөр Эрх бүхий гэрээ тус бүрийн Эрх бүхий үнийн дүнд 0.50% (тэг зууны таван хувь)-ийн үйлчилгээний шимтгэлийг Зээлдэгч ЭКСИМ банканд нэг удаа төлнө.

**7.3 Хэрэв ямарваа шалтгаанаар эрх бүхий гэрээний эрх бүхий үнийн дүнг бүрэн буюу хэсэгчлэн зарцуулаагүй байсан ч ЭКСИМ банк Зээлдэгчид ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд төлсөн хүү болон үйлчилгээний шимтгэлийг буцаан олгохгүй.**

**8. Дефолтын хүү:**

- 8.1 Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Зээлдэгч үндсэн төлбөр, хүүгийн төлбөр болон бусад төлбөрийн зөрчил гаргасан бол уг төлөгдөөгүй дүнд тооцогдох нэмэлт хүү-г ЭКСИМ банканд төлнө. Тус нэмэлт хүүг төлбөр хийгдэх ёстой байсан өдрөөс төлбөрийг хийсэн өдөр хүртэл (шийдвэр гарахаас өмнө болон хойно) эхлэн Хүүгийн хэмжээнээс дээш хувиар буюу жилийн 2% (хоёр хувь)-иар тооцно.
- 8.2 Дээр дурдсан хүүгийн хэмжээгээр өдөр, өдрөөр хурумтлагдах бөгөөд нэг жилд 360 хоног байхаар бодож хугацаа хэтэрсэн бодит хоногт үндэслэн тооцно.

**9. Урьдчилсан нөхцөл:**

- 9.1 ЭКСИМ банкнаас Зээлдэгч нь доорх баримт бичгүүдийг хүлээн авч, шаардлага хангасан гэж үзэж албан бичгээр мэдэгдсэний дараа Хэлэлцээр хүчин төгөлдөр болно. Үүнд:
  - a) Зээлдэгчийн хуульчаас гаргасан Хууль зүйн дүгнэлт /Хавсралт II-т

Монгол Улсын Сангийн даан  
Дэдэкан дээдэлтэйгээ Чуудалд

Гарын чадлыг  
1 2 3 4 5 6

- заасны дагуу/;
- b) Зээлдэгчийн эрх бүхий этгээдийн гарын үсгийн баталгаа /Хавсралт V-т заасны дагуу/;
- c) ЭКСИМ банкнаас авах хууль ёсны болон бусад шаардлагатай зөвшөөрөл.
- 9.2 ЭКСИМ банк нь энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болж, доорх шаардлагуудыг биелүүлсний дараа аливаа гэрээг энэхүү Хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэх боломжтой гэж үзэж, Зээлдэгчийн дансанд мөнгө олгоно. Үүнд:
- a) ЭКСИМ банк нь Зээлдэгчээс уг төсөл нь зээлдэгчийн улсад мөрдөгдөж буй хууль, журам болон төсөвтэй холбоотой зөвшөөрлөө авсан тухай баталгааг өгөх;
  - b) Зээлдэгч нь ЭКСИМ банканд төслийн хэрэгжилтийн хүрээнд мөрдөх бүх хууль тогтоомж/ журмын зохицуулалт/ төсвийн шаардлагыг биелүүлсэн тухайгаа баталгаажуулж, Зээлдэгчийн нутаг дахь Төсөл хэрэгжүүлэх газар, зөв арга зам, суурь дэд бүтэц, цахилгаан, ус зэргийг бэлэн болгосон байх эсвэл үүний хүрээнд шаардлагатай арга хэмжээг авсан байх;
  - c) ЭКСИМ банк нь Зээлдэгчийн татвар, гаалийн татвараас чөлөөлсөн тухай баталгаа, санхүүгийн асуудлыг хаасан бичиг баримт болон Зээлдэгчийн төсөлтэй холбоотойгоор гаргасан бусад амлалтуудыг биелүүлсэн тухай баталгааг гэрээний хуулбарын хамт хүлээн авна.
  - d) энэхүү Хэлэлцээрийн дагуу Зээлдэгч төлбөл зохих аливаа төлбөр, хүү, хураамж, зарлага зэргийг заасан хугацаанд нь ЭКСИМ банканд төлсөн;
  - e) Энэхүү Хэлэлцээрийн Ерөнхий нөхцөлийн дагуу Зээлдэгчийн гаргах бүхий л мэдээлэл, баталгаа нь Зээлийн Урьдчилгаа гаргах тухай бүрд үнэн, зөв хэвээр байвал зохих ба өөрөөр хэлбэл урьдчилгаа хийх үед үүссэн ямарваа нөхцөл, байдалд дээрх мэдээлэл ижил байх гэсэн үг болно;
  - f) Ямарваа төлбөрийн зөрчил гараагүй буюу гарахгүй байх;
  - g) ЭКСИМ банк нь 4-р зүйлд заасан баримт бичиг болон Хавсралт I-ын дагуу Гэрээ батлах маягт болон Хавсралт V-т заасан Зээлдэгчээс эрх олгосон этгээд гарын үсэг зурсан Төлбөрийн зөвшөөрлийг Хавсралт III-ын дагуу ашиглалт гарах сүүлийн өдрөөс өмнө ирүүлсэн байх;

## 10. Аюулгүй байдал

Монгол Улсын Сангийн яам  
РАН ЕСНЫ ОРЧУУЛГА МЕН

Гарын үсэг /Signature/ .....

20 жилийн 1 сарын 6-ны өдөр

Улаанбаатар хот

10.1 Зээлдэгчийн зүгээс энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор Монгол Улсад байгаа Эксим банк (Дансны банк)-инд зөвшөөрөгдөх банкинд зориулалтын дан ганц төслийн данс ("Төслийн данс") үүсгэх болон байгуулна. Төслийн данстай холбоотойгоор Зээлдэгч болон Эксим банк нь дараах зүйлсийг тохиролцов:

- Зээлдэгч нь Төслийн бүх орлого болон авлага нь төслийн дансаар дамжахыг баталгаажуулах бөгөөд өөр Төслийн Эрх бүхий байгууллагын энэхүү авлагыг хүлээн авах данс нээхгүй бөгөөд үүсгэх байх нөхцлийг бүрдүүлнэ.
- Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Зээлдэгчийн төлбөрийн үүргийг баталгаажуулах хүрээнд Зээлдэгч нь Эксим банкыг дараах эрхтэй болохыг хүлээн зөвшөөрсөн i) Төслийн дансанд байгаа эх үүсвэрт анхны болон онцгой төлбөрийн эрхтэй мөн ii) зөвхөн Дефолтод орсон тохиолдолд Төслийн дансыг царцаах болон энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Зээлдэгчийн хүлээсэн төлбөрийн үүрэг гүйцэтгүүлэх зорилгоор эх үүсвэрийг ашиглана.
- ЭКСИМ банкны цорын ганц эрх болон Зээлдэгчийн дээр дурдсан үүргийг хүчинтэй болгох хүрээнд Зээлдэгч нь ЭКСИМ банканд хүлээн зөвшөөрөгдөх баталгааг бий болгох, боловсронгуй болгоход тохирсон баримт бичгийг өөрийн зардлаар гүйцэтгүүлж, баталгаажуулна.

10.2 10.1(b)-т заасны дагуу Дефолтод орсон тохиолдолд ЭКСИМ банкны зүгээс Төслийн дансыг царцаах эрхээ хэрэгжүүлж, цаашид ЭКСИМ банкны зөвшөөрөлгүйгээр данснаас аливаа зарлага гарахыг хориглоно.

10.3 Зээлдэгч нь Төслийн дансыг үүсгэж, хадгалаагүй тохиолдолд Дефолтод орсон гэж үзэх бөгөөд ЭКСИМ банкны зүгээс энэхүү Хэлэлцээрийн хүрээнд олгосон зээл болон Зээлдэгчид олгосон бусад зээлийн эх үүсвэрийн ашиглалтыг шууд зогсоох эрхтэй.

## 11. Амлалт

Зээлдэгч нь Төслийн одоогийн болон ирээдүйн орлогыг барьцаалахгүй гэдгийг илэрхийлж байгаа бөгөөд энэхүү Хэлэлцээрийн дагуу төлөгдөх буюу төлөгдөөгүй үлдэгдэл төлбөр байгаа цагт ЭКСИМ Банкнаас урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Төслийн одоогийн болон ирээдүйн орлогод ямар нэгэн дарамт үүсгэх, эсвэл дарамт бий болгох зөвшөөрлийг өгөх, хүлээж авах, зөвшөөрөхгүй байх үүрэгтэй.

## 12. Авлигын эсрэг хууль

12.1 Хэлэлцэн тохирогч талууд /дангаар эсвэл энэхүү Хэлэлцээрт оролцсон гуравдагч этгээдэд/ нь энэхүү хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх болон/эсвэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны нөхөн

төлбөр, санхүүгийн болон санхүүгийн бус давуу тал олгохыг болон оролцогч талуудын аль нэгний үндэсний хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хууль зөрчсөн үйлдэл гэх мэтийг өөртөө эсвэл гуравдагч этгээдийн өмнөөс санал болгох, асуух, эсвэл хүлээн зөвшөөрөхийг хориглоно.

- 12.2 Энэхүү хэлэлцээрийн дагуу 12.1 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаа эсвэл нөхцөл байдалд суурилсан аливаа гэрээ нь эдгээр үйл ажиллагаанд оролцсон хүмүүсийн эсрэг эцсийн иргэний болон эрүүгийн үр дагаврыг харгалзалгүй хүчингүйд тооцох болно.

### 13. Ил тод, шударга байдал

Зээлдэгч нь энэхүү хэлэлцээрийн хүчинтэй байх хугацаанд ёс зүй, шударга байдлыг хамгийн өндөр түвшинд байлгах шаардлагатай бүх арга хэмжээг авах үүргийг үүгээр хүлээн зөвшөөрч худалдагч, тендерт оролцогч, нийлүүлэгч, гэрээт гүйцэтгэгчид, агентууд, зөвлөхүүд, туслан гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчид болон бүх ажилтан нь тухайн төсөлтэй холбогдох Төслийн Дэлгэрэнгүй Тайлан зэрэг уг хэлэлцээрийн дагуу төслийн хэрэгжилттэй холбогдуулан хийгдэх ажил, тендерт шалгаруулалтад оролцох, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэлийн үйл явцын туршид үүргээ ноцтой зөрчих явдлаас өөрсдийн хүрээнд боломжит, шаардлагатай бүх арга хэмжээг авна.

### 14. Зээлийн хэлэлцээрийн бүрэлдэхүүн хэсэг болох Ерөнхий нөхцөл:

Энэхүү Хэлэлцээр нь хавсралтад заасан Ерөнхий нөхцөлийн хамт нэг хэлэлцээр хэмээн тооцогдоно. Ерөнхий нөхцөл нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг бөгөөд түүнийг энэхүү Хэлэлцээрт ишлэн оруулсандаа тооцно. Талууд Ерөнхий нөхцөлийн заалтуудыг хүлээн зөвшөөрч, заавал дагаж мөрдөхөөр тохиролцов.

ХАВСРАЛТ

## Ерөнхий нөхцөлүүд

- A. Тодорхойлолт ба тайлбар
  - B. Зээлдэгчийн хүлээх үүрэг
  - C. Хүү төлөх хугацаа
  - D. Татвар
  - E. Дансны мөнгөн тэмдэгт болон төлбөр хийх газар
  - F. Төлбөрийн зориулалт
  - G. Нөхөн төлбөр
  - H. Мэдэгдэл
  - I. Хэлцэл хийх нөхцөл
  - J. Хяналт шалгалт, мониторинг
  - K. Дефолтын нөхцөл байдал
  - L. Өрийн нотолгоо
  - M. Татгалзал
  - N. Эрх шилжүүлэх
  - O. ЭКСИМ банкны баталгаажуулалт
  - P. Хэсэгчлэн хүчингүй болох
  - Q. Баримт бичгийн хэл
  - R. Хууль
  - S. Арбитр
  - T. Мэдэгдэл

## ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД

### A. Тодорхойлолт ба тайлбар

Энэхүү хэсэгт өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд Зээлийн Хэлэлцээрт тодорхойлсон, энэхүү Ерөнхий нөхцөлд хэрэглэгдэж буй бүх үг хэллэг нь Зээлийн Хэлэлцээрт заасантай ижил утгатай байна. Зээлийн хэлэлцээрийн заалт болон Ерөнхий нөхцөлийн заалт хооронд зөрүү гарвал Зээлийн хэлэлцээрийн заалтыг баримтална.

### B. Зээлдэгчийн хүлээх үүрэг

Энэхүү Хэлэлцээрийн дагуу Зээлдэгчийн төлбөр хийх үндсэн үүрэг нь ямар ч тохиолдолд Худалдагч эрх бүхий гэрээгээр хүлээсэн үргээ зохих ёсоор биелүүлсэн эсэхээс үл хамаарах бөгөөд түүнчлэн Худалдагч, Худалдан авагчийн хооронд гарсан аливаа маргаан, Худалдагчийн эсрэг нэхэмжлэл гаргах Худалдан авагчийн эрх үүнд нөлөөлөхгүй. Тэрчлэн Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрийн дагуу ЭКСИМ банканд төлөх аливаа төлбөрийг шийдвэрлэх үүднээс өөрийн Худалдан авагчтай тогтоосон ажил хэргийн буюу хэлэлцээрийн харилцаатай холбогдуулан ямар нэг хориг арга хэмжээ авах эрхгүй.

### C. Хүү төлөх хугацаа:

- (1) Урьдчилгаа, эсхүл Зээлийн эргэн төлөх үлдэгдэлтэй хугацаа нь хоорондоо 6 сарын зйтай эсхүл тухайлан өөрөөр тогтоосон хугацаа бүхий дараалсан хугацаануудад ("Хүү төлөх хугацаа" гэх) хуваагдана.
- (2) Эрх бүхий гэрээ бүрийн эхний Хүү төлөх хугацаа нь Урьдчилгаа гарсан өдрөөс эхлэн тооцогдох бөгөөд эхний эрх бүхий гэрээний эхний ашиглалтын хувьд эхний Хүү төлөх хугацаа нь тухайн хүү төлөх хугацаа эхэлснээс хойш тохиох эхний Хүү төлөх өдрөөр дуусгавар болно.
- (3) Урьдчилгаа гарсан эрх бүхий гэрээний эсвэл бусад эрх бүхий гэрээний хүрээнд гарсан Урьдчилгааны эхний Хүү төлөх хугацаа нь одоо үйлчилж буй Хүү төлөх хугацааны сүүлийн өдөр дуусгавар болно.
- (4) Хүү төлөх хугацаа бүр (Урьдчилгаа бүрийн эхний хүү төлөх хугацаанаас бусад) өмнөх хүү төлөх хугацааны дараагийн өдөр шууд эхлэх бөгөөд хамгийн ойрын Хүү төлөх өдөр дуусгавар болно.
- (5) Аливаа хүү төлөх хугацаа өмнөх сарын дундуур дуусах буюу эсхүл сүүлийн Эргэн төлөх өдрөөс хэтрэх бол уг хугацаа Е.4

хэсэгт зааснаар дуусгавар болно.


- (6) Хэрэв хоёр ба түүнээс дээш хүү төлөх хугацааны эхлэх болон дуусах өдөр нь нэг өдөр байвал тухайн хүү төлөх хугацаанд хамаарах Урьдчилгааг нэгтгэж, нэг Урьдчилгаа гэж тооцно.

**D. Татвар:**

- D.1 Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрийн дагуу төлөх бүх төлбөрийг түүнд өөрчлөлт оруулах, сөрөг нэхэмжлэл гаргах буюу ямар нэг болзол, хязгаарлалтгүйгээр Зээлдэгчийн улсын Засгийн газраас одоо болон цаашид ногдуулах бүх төрлийн татвар, суутгал, шимтгэл ("Татвар" гэх)-ийг үл оролцуулан бүрэн төлнө. Хэрэв (i) хуульд зааснаар Зээлдэгч энэхүү Хэлэлцээрийн дагуу хийх ямарваа төлбөрөөс суутгал тооцох буюу шимтгэл авах шаардлагатай бол, эсхүл; (ii) хуулийн дагуу ЭКСИМ банк энэхүү Хэлэлцээрийн дагуу хүлээн авсан буюу хүлээн авах төлбөртэй холбогдуулан татвар (нийт орлогод ногдох татвараас бусад) төлөх шаардлагатай, эсхүл Зээлийн сан бий болгох зорилгоор өөрийн Зээлдүүлэгч (нар)-ээс авсан зээлийг төлөх болбол Зээлдэгч төлбөр хийхдээ суутгал, шимтгэл, төлбөр зэргийг тооцон төлбөрийн дүнг нэмэгдүүлэх ба тэдгээр суутгал, шимтгэл, төлбөрийг тооцсоны дараа ЭКСИМ банк авбал зохих суутгал, шимтгэл буюу аливаа төлбөр тооцоогүй мөнгөн дүнг авна (суутгал, шимтгэл, төлбөр зэргийн талаар ямарваа үүрэг хүлээхгүй).
- D.2 Зээлдэгч нь энэхүү хэлэлцээрт заасан төслийн бүтээн байгуулалтын хугацаанд ашиглах гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар импортолсон техник тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгслийг болон бусад хөрөнгийг төсөл хэрэгжиж дуусах хүртэл түр хугацаагаар байршуулахыг зөвшөөрнө.
- D.3 Хуулийн дагуу Зээлдэгчийн хийх төлбөрөөс аливаа суутгал, шимтгэл авсан тохиолдолд Зээлдэгч тэрхүү төлбөрөөс суутгал, шимтгэл тооцсоныг нотлох холбогдох татварын буюу бусад байгууллагын баримтыг төлбөр хийснээс хойш 30 хоногийн дотор ЭКСИМ банканд хүргүүлнэ.
- D.4 Зээлдэгч нь Зээлийн Хэлэлцээр (хууль ёсны болсон эсэхээс үл хамааран)-ийн дагуу төлөх аливаа төлбөртэй холбогдуулан ямар нэг татвар төлөх үүрэг хариуцлагыг ЭКСИМ банканд хүлээлгэхгүй.
- D.5 Хэрэв Зээлдэгч нь энэ хэсгийн D.1-д заасан суутгал, шимтгэл, төлбөрийн талаар олж мэдсэн бол нэн даруй ЭКСИМ банканд мэдэгдэж, боломжтой бүх мэдээллээр хангана.

**E. Дансны мөнгөн тэмдэгт болон төлбөр хийх газар:**

- E.1 Энэхүү Хэлэлцээрийн дагуу төлбөрийн дансны мөнгөн тэмдэгт нь доллар байх бөгөөд Зээлдэгч Зээлийн хэлэлцээрийн дагуу ямар ч үед төлбөрийг доллараар хийнэ.
- E.2 Хэрэв энэхүү Хэлэлцээрийн дагуу, эсхүл тодорхой шийдвэрийн талаар гарсан арбитрын шийдвэрийн дагуу Зээлдэгчийн төлөх аливаа төлбөрийн дүнг (i) Зээлдэгчийн эсрэг нэхэмжлэл, нотолгоо гаргах, (ii) тодорхой шийдвэрийн талаар арбитрын шийдвэр гаргуулах, (iii) тухайн арбитрын шийдвэрийг биелүүлэх, (iv) бусад шалтгаанаар Зээлдэгчийн үүрэг хариуцлагыг баталгаажуулах зэрэг зорилгоор дээрх мөнгөн тэмдэгт ("Анхны мөнгөн тэмдэгт")-ээс өөр мөнгөн тэмдэгт ("Хоёрдогч мөнгөн тэмдэгт") рүү хөрвүүлэх шаардлагатай бол дээрх нэхэмжлэл, нотолгоог гаргасан өдөр эсхүл арбитрын шийдвэр гарсан өдрийн өмнөх ажлын өдөр дуусах үеийн, арилжааны банкнаас ЭКСИМ банканд санал болгосон чөлөөтэй шилжих долларын арилжааны ханшаар тооцож хөрвүүлнэ. Ингэхдээ Зээлдэгч нь (a) төлбөрийг анхны мөнгөн тэмдэгтээс хоёрдогч мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэх арилжааны ханш болон (b) тухайн нэхэмжлэл, арбитрын шийдвэрийн дагуу холбогдох мөнгөн дүнг бүрэн буюу хэсэгчлэн төлсөн тухай баримтыг хүлээн авснаар ердийн үед ЭКСИМ банк хоёрдогч мөнгөн тэмдэгтээр анхны мөнгөн тэмдэгтийг худалдан авах арилжааны ханш хоорондын зөрүүнээс үүдэн ЭКСИМ банканд аливаа алдагдал учрахаас сэргийлж, учирсан хохирлыг нөхөн төлнө. Энэхүү дэд хэсгийн зорилгоор болон дээр дурдсан нөхөн төлбөрийн талаарх зохицуулалтыг хөндөхгүйгээр, хэрэв шүүхийн тодорхой шийдвэрийн талаар гарсан арбитрын шийдвэр хоёрдогч мөнгөн тэмдэгтээр хийгдсэн бол энэ нь ердийн үед ЭКСИМ банк хоёрдогч мөнгөн тэмдэгтээр анхны мөнгөн тэмдэгтийг худалдан авахад ашиглах төлбөр хийх өдрийн арилжааны ханшаар тооцсон зохих дун бүхий төлбөрийг анхны мөнгөн тэмдэгтээр хүлээн авах бололцоотойгоор хийгдсэн байхыг хуулиар зөвшөөрөгдөх хүрээнд баталгаажуулахыг Зээлдэгч зөвшөөрөв.
- E.3 Зээлдэгч ЭКСИМ банканд төлөх бүх төлбөрийг доллараар хийх бөгөөд ЭКСИМ банкны Энэтхэг Улс дахь тусгайлан заасан банк, эсхүл гадаад улсын банкин дахь дансанд шилжүүлнэ. Төлбөрийг ЭКСИМ банк валютын харьцуулсан нэрийтгэл ханшаар төлбөр хийх өдөр буюу түүнээс өмнө хүлээж авах боломжтой байхаар хийнэ. ЭКСИМ банк өөрөөр тусгайлан мэдэгдээгүй бол, Зээлдэгч төлбөрийг ЭКСИМ банкны Exim Bank A/c. No. 36046887, Citibank N.A., New York, U.S.A., CHIPS UID



173871 дансанд шилжүүлнэ. Төлбөрийг аливаа суутгалгүйгээр ЭКСИМ банкны заасан дансанд шилжүүлж, тус банк чөлөөтэй захиран зарцуулах боломжийг бүрдүүлснээр Зээлдэгч төлбөр хийх үүргээ биелүүлсэн гэж тооцно.

- E.4 Хэрэв Зээлийн хэлэлцээрийн дагуу төлбөр хийх өдөр нь тухайн төлбөр хийх газар, эсхүл ЭКСИМ банкны хувьд ажлын бус өдөр байвал дараагийн ажлын өдөр төлбөрийг хийнэ. Хэрэв тэрхүү дараагийн ажлын өдөр нь дараагийн хуанлийн сард тохиож буй бол төлбөрийг өмнөх ажлын өдөр хийх ба шаардлагатай тохиолдолд хүү болон хураамжийг зохих ёсоор тооцно.

#### **F. Төлбөрийн зориулалт:**

- F.1 Хэрэв ЭКСИМ банк шаардаагүй бол энэхүү Зээлийн хэлэлцээрийн дагуу ЭКСИМ банканд төлөх төлбөр нь дор дурдсан зориулалттай байх ба Зээлдэгч өөр ямар нэг зориулалтаар төсөвлөх эрхгүй:

  - (a) Үнэ ба зардал;
  - (b) Төлбөр;
  - (c) Төлбөрийн зөрчил дээр тооцох нэмэлт хүү;
  - (d) Нийлмэл хүү;
  - (e) Хүү;
  - (f) Зээлийн хэлэлцээрийн дагуу төлөх үндсэн төлбөр.

## G. Нөхөн төлбөр:

Зээлдэгч Зээлийн Хэлэлцээрээр хүлээсэн үүргээ зөрчсөн, эсхүл зөрчилд тооцогдох тохиолдол илэрсэн, эсхүл зээлийн аливаа хэсгийг буюу хугацаа хэтэрсэн төлбөрийг ЭКСИМ банканд зохих эргэн төлөх өдөр буюу хүү төлөх өдрөөс хугацаа хоцроож төлсөн, нөхөн төлсөн зэргээс шалтгаалан ЭКСИМ банканд учирсан бүхий л алдагдал, өр, хохирол, зардал, төлбөр болон зарлага (үүнд Зээлийг бүрдүүлэх, эсхүл Урьдчилгаа төлөх болон төлөгдөөгүй үнийн дүнг санхүүжүүлэхэд гарсан аливаа зардал, хүүг шийдвэрлэх зорилгоор бий болгож төвлөрүүлсэн хөрөнгийг нөхөн төлөхтэй холбоотойгоор гарсан зардал мөн хамаарна) зэргийг түүний нотолсноор нөхөн төлнэ.

## Н. Мэдэгдэл, баталгаа:

- #### H.1 Зээлдэгч нь дараах зүйлсийг мэдэгдэж байна:-

- а) Энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан албан тушаалтан(ууд) нь Зээлийн Хэлэлцээрийг Зээлдэгчийн нэрийн өмнөөс байгуулах, хэрэгжүүлэх бүрэн эрх, эрх зүйн чадамжтай ба Зээлдэгчид олгох зээлийг батлах, Зээлийн Хэлэлцээр болон түүнд холбогдох бүхий л баримт бичгийг байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэхэд шаардлагатай (хуульд заасан болон бусад) арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болохыг;
- б) Зээлдэгч Зээлийн Хэлэлцээрийг байгуулах, түүгээр олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах, Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээхээр заасан үүрэг нь хууль ёсны, үндэслэлтэй, хэрэгжүүлэх бололцоотой байхыг тус тус хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг Зээлдэгчийн улсын хууль тогтоомжид чанд нийцүүлэн авч хэрэгжүүлсэн бөгөөд тэдгээр нөхцөлүүдийг биелүүлэх явцад аливаа зөрчил гараагүй болохыг;
- с) Зээлийн хэлэлцээрийн дагуу Зээлдэгчийн хүлээхээр заасан үүрэг, хариуцлага нь Зээлдэгчийн хууль ёсны, хүчин төгөлдөр дагаж мөрдөх, түүнчлэн ямарваа нөхцөл болзолгүйгээр шууд хүлээх нийтлэг үүрэг хариуцлага бөгөөд эдгээр нь түүний бусад үүрэг хариуцлагатай ижил түвшинд тооцогдох болохыг;
- д) Төслийн одоогийн болон ирээдүйн орлогыг барьцаалаагүй байх;
- е) Зээлийн Хэлэлцээр болон Төлбөрийн нотолгооны хууль ёсны, хүчин төгөлдөр, үндэслэлтэй, хэрэгжүүлэх боломжтой байдлыг Зээлдэгчийн улсад баталгаажуулах үүднээс тэдгээр болон өөр бусад баримт бичгийг мэдээллийн санд оруулах, нотариатаар баталгаажуулах, бүртгэх, тэмдэглэх буюу аливаа шүүх, эрх бүхий байгууллагын бүртгэлд оруулах, тамга дараах, бүртгэх, Зээлийн Хэлэлцээр болон түүнтэй холбогдуулан аливаа татвар төлөх шаардлагагүй болохыг;
- ф) Зээлийн Хэлэлцээр болон түүний дагуу байгуулагдсан баримт бичгүүдийн дагуу хүлээх үүрэгтэй холбоотойгоор Зээлдэгч нь иргэний болон худалдааны хууль тогтоомжид захирагдаж, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагаанд харьяалагдах ба зээл авах ажиллагаа, Зээлийн Хэлэлцээрийг байгуулах, Зээлдэгч түүний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх зэрэг нь төрийн бус харин хувийн, арилжааны үйл ажиллагаанд тооцогдоно. Зээлдэгч нь бүрэн эрхт байдал болон бусад үндэслэлээр зээлдэгчийн улс дахь аливаа хууль эрх зүйн үйл явцаас халдашгүй эрх эдлэх эрхгүй бөгөөд энэхүү Хэлэлцээрт тусгагдсан халдашгүй дархан байдал, онцгой эрхээс татгалзах үүргийг Зээлдэгч заавал биелүүлэх болохыг;
- г) Зээлийн Хэлэлцээрийг биелүүлэхтэй холбогдуулан

- Зээлдэгчийн улсад явагдах аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Зээлийн Хэлэлцээрийг зохицуулах хуулиар Энэтхэгийн хуулийг сонгосон нь хүчин төгөлдөр бөгөөд Зээлийн Хэлэлцээртэй холбоотойгоор гарсан шүүхийн аливаа тогтоол, шийдвэр, арбитрын шийдвэрийг Зээлдэгчийн улсын шүүх хүлээн зөвшөөрч, биелүүлэхийг;
- h) ЭКСИМ банк нь зөвхөн Зээлийн Хэлэлцээрийг байгуулж, хэрэгжүүлэх шалтгаанаар Зээлдэгчийн улсад байнга байрлах буюу үйл ажиллагаа явуулахгүй.
  - i) Зээлийн Хэлэлцээр, эсхүл Төлбөрийн зөвшөөрлийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх болоод Зээлдэгч Зээлийн Хэлэлцээрээр олгогдсон эрхээ эдлэх нь Зээлдэгчийн заавал биелүүлэх буюу түүний одоогийн болон ирээдүйн хөрөнгө орлогод үйлчлэх аливаа хууль тогтоомж, зөвшөөрөл, шүүхийн шийдвэр, тогтоол, гэрээ, баримт бичиг болон үүргийг зөрчихэд хүргэх буюу тэдгээртэй зөрчилдөхгүй, Зээлдэгчийн одоогийн болон ирээдүйн хөрөнгө орлогод бүхэлд нь буюу түүний тодорхой хэсэгт хориг саад учруулах, эсхүл Зээлдэгчид дээрх хориг саадыг бий болгох үүрэг ногдуулахгүй,
  - j) Зээлдэгч Зээлийн Хэлэлцээрээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх чадавхад бодит сөрөг нөлөө үзүүлэхүйцээр, Зээлдэгчийн заавал биелүүлэх буюу түүний одоогийн болон ирээдүйн хөрөнгө орлогод үйлчлэх аливаа хууль тогтоомж, зөвшөөрөл, гэрээ, баримт бичиг болоод үүргийг зөрчөөгүй болохыг;
  - k) Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээсэн төлбөр төлөх үүргээ биелүүлэх зорилгоор Зээлдэгчийн хийх гадаад мөнгөн шилжүүлэгт тогтоосон аливаа хязгаарлалт, саад байхгүй болохыг;
  - l) К.1 хэсэгт дурдсан тохиолдол, эсхүл тэдгээр тохиолдолд тооцогдох (мэдэгдэл хүргүүлснээр, тодорхой хугацаа өнгөрснөөр, эс бөгөөс бодит нөхцөл байдлаас улбаалсан) магадлал бүхий тохиолдол үүсээгүй, түүнчлэн заасан хугацаанаас өмнө өрөө төлж барагдуулахыг Зээлдэгчид мэдэгдэх, Зээлдэгчид аливаа зээл олгохыг, зогсоох, цуцлах, эсхүл урьдчилгаа төлөхөөс татгалзах зэрэг эрхийг түүний зээл олгогчид олгож буй буюу мэдэгдэл хүргүүлсэн нөхцөлд болон хугацаа дуусахад ийм эрх олгохуйц тохиолдол үүсээгүй гэдгийг; мөн
  - m) Энэхүү Гэрээг байгуулсан өдрөөс өмнө Зээлдэгчээс ЭКСИМ банканд гаргаж өгсөн мэдээлэл нь үнэн, зөв бөгөөд алдаагүй, аливаа төөрөгдүүлэх утга агуулаагүй болох.

## I. Хэлцэл хийх баталгаа:

Зээлдэгч дор дурдсан зүйлсийг гүйцэтгэхийг зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээж байна. Үүнд:

- a) Зээлийн хөрөнгийг Зээлдэгчийн улсын Худалдан авагч Энэтхэг Улсаас Эрх бүхий барааг худалдан авахад зарцуулах;
- b) Зээлдэгч Зээлийн Хэлэлцээрийг хууль ёсны дагуу байгуулах, Зээлийн Хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх, түүнчлэн Зээлийн Хэлэлцээрийг хууль ёсоор хүчин төгөлдөр болгох, хэрэгжүүлэхэд Зээлдэгчийн улсын хууль тогтоомжийн дагуу шаардагдах бүх зөвшөөрөл, баталгаа, лиценз зэргийг авч, мөрдөж ажиллах;
- c) К.1 хэсэгт дурдсан тохиолдол; эсхүл тэдгээр тохиолдолд тооцогдох магадлал бүхий (мэдэгдэл хүргүүлснээр, тодорхой хугацаа өнгөрснөөр, эс бөгөөс бодит нөхцөл байдлаас улбаалсан) аливаа тохиолдлын талаар ЭКСИМ банканд нэн даруй мэдэгдэх;
- d) Зээлдэгч буюу түүний аливаа хөрөнгийн эсрэг шүүхэд зарга мэдүүлсэн, арбитрын шүүхэд хандсан, захиргааны арга хэмжээ авсан, эсхүл хэлэлцээрийн дагуу нэхэмжлэл гаргасан зэрэг Зээлдэгчийн Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх чадавх, эсвэл санхүүгийн байдалд бодит хохирол учруулах буюу сөргөөр чөлөөлж болзошгүй үйлдлүүдийн талаар ЭКСИМ банканд нэн даруй мэдэгдэх;
- e) Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээх үүргээ Зээлдэгч ямагт аливаа нөхцөл болзолгүйгээр, шууд хэрэгжүүлэх ба нийтлэг үүрэг, хариуцлага түүний бусад үүрэг, хариуцлагатай ижил түвшинд авч үзэх;
- f) Төслийн хүрээнд аливаа нэмэлт санхүүжилт, эх үүсвэр шаардлагатай болсон тохиолдолд түүнийг санхүүжүүлэх;
- g) ЭКСИМ банканд зөвшөөрөгдөх баталагааг Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор бий болгох;
- h) Энэхүү Зээлийн хэлэлцээрийн хүрээнд эргэн төлөгдөх төлбөр болон өр байгаа хугацаанд ЭКСИМ банкнаас олгож буй энэхүү зээлийн эх үүсвэрийг Зээлдэгчийн болон Төслийн эрх бүхий байгууллагын Төсөлтэй холбостойгоор бий болгосон бусад өр болон үүрэг хариуцлагаас дээгүүр бүртгэх;
- i) Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүргээ бүрэн, үр дүнтэй гүйцэтгэхийн тулд гуравдагч этгээд болон бусад этгээдээс шаардлагатай бүх шийдвэр, зөвшөөрлийг авах;
- j) Төслийн орлогод ямар нэгэн гуравдагч этгээд ЭКСИМ банкны

эрхээс илүү эрх олж авахгүй байх нөхцлийг бүрдүүлэх бүх арга хэмжээг авах;

- k) Хэрэв Зээлдэгчийн улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн бүртгэл, тооцоо хийх зарчим, тогтсон журмын дагуу шаардагдах эсэхэд маргаан үүссэнээс бусад тохиолдолд Зээлдэгчийн хөрөнгө, ашиг, орлогод хохирол учруулж болохуйц бүх төрлийн хууль ёсны нэхэмжлэлийг төлөх буюу төлөх арга хэмжээ авах;
- l) Үйл ажиллагааг хэрэгжүүлэх өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг Шинэ Дэли хотод томилон ажиллуулах ба Зээлийн хэлэлцээрийн дагуу ЭКСИМ банканд төлбөл зохих бүх төлбөрийг төлж дуусах хүртэл хэрэв ЭКСИМ банк хүлээн зөвшөөрсөн өөр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсноос бусад тохиолдолд тэрхүү төлөөлөгчөөр дамжуулан харилцах харилцааг зогсоохгүй. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн томилгоо, түүний хаягийн өөрчлөлт, явцдаа буй томилгоо зэргийн талаар ЭКСИМ банканд мэдэгдэх ба тэдгээрийн хувийг шуудангийн үйлчилгээний хураамжийг урьдчилан төлж захиалгат шуудангаар Хэлэлцээрт заасан Зээлдэгчийн хаягаар хүргүүлсэн нь Зээлдэгчийн зөвшөөрлөөр хийгдэж буй хувийн үйлчилгээ хэмээн үзэх ба энэ нь арбитрын шүүхэд лавлагааны зорилгоор ашиглахад заавал биелэгдэх шинжтэй байна.

## J. Хяналт шалгалт, мониторинг:

### J.1 Хяналт шалгалт

Зээлдэгч Зээлийн хэлэлцээрийн дагуу төлбөл зохих бүх төлбөрийг төлж барагдуулах хүртэл ЭКСИМ банкны төлөөлөгчид Худалдан авагчийн авсан зээл, үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэл тооцоонд хяналт шалгалт хийхэд туслалцаа үзүүлж, тэдгээрийн ажилтан, албан хаагчид нь бүрэн хамтарч ажиллахыг хариуцна. ЭКСИМ банк нь хяналт шалгалт хийх эрхээ хязгаарлагдмал хүрээнд хэрэгжүүлэх ба уг хяналт шалгалт нь ЭКСИМ банкны хөрөнгөөр санхүүжигдэж буй Худалдан авагчийн төслийн хүрээнд хийгдэнэ хэмээн ойлгоно. Зээлдэгч нь Худалдагч, тендерт оролцогч, нийлүүлэгч, гэрээлэгч, зөвлөхүүд, ажилтнууд, дэд гэрээлэгч, үйлчилгээ үзүүлэгч, болон бусад холбогдох ажилтнуудтай зөвшилцэж, сонгон шалгаруулалт болон гэрээний гүйцэтгэлтэй холбоотой данс, тайлан болон бусад холбогдох баримт бичгүүдийг хянан шалгах мён энэхүү хэлэлцээрийн хугацаанд Энэтхэг Улсын Засгийн газар/ЭКСИМ банкнаас томилсон аудитораар аудит хийлгэх эрхийг Энэтхэг Улсын Засгийн газар/ЭКСИМ банканд олгоно.

Монгол Улсын Сангийн зам  
АН ЕСНЫ ОРЧУУЛГА МЭДЛЭЛ

..... /Signature/ .....  
Хонойн / сарын 6 өдөр

Улаанбаатар хот

## J.2 Төсөл(үүдийн)-ийн мониторинг /Эрх бүхий гэрээ (нүүд)

Зээлдэгч нь Эрх бүхий гэрээний гүйцэтгэлийн явцын тайланг дараах хугацаанд:

- a) Эрх бүхий гэрээ батлагдсанаас хойш гэрээ дуусах хүртэлх хугацаанд 3 сар бүр хүргүүлнэ.
- b) Зээлдэгч өөрийн санхүүжилтээр Төсөл /эрх бүхий гэрээ хэрэгжиж дуусах үед төслийн хүрээнд гарсан үр ашиг/төспөөс гарах үр ашиг болон төслийн Зээлдэгч улсад үзүүлсэн нийгэм, эдийн засгийн бодит үр нөлөөллийг тусгасан дэлгэрэнгүй тайланг боловсруулж, хүргүүлнэ.
- c) ЭКСИМ банк Төсөлд бие даасан хяналт тавих Зээлдүүлэгчийн инженерийг томилж болно. Зээлдүүлэгчийн инженерийн үүрэг бол цаг хугацаа, чанарын үзүүлэлтүүдийг мөрдүүлэх, шаардлагатай тохиолдолд төслүүдийг амжилттай, цаг тухайд нь хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг эхлүүлнэ. Зээлдэгч нь Төсөлтэй холбоотой Худалдагч, гүйцэтгэгч, зөвлөхүүд Зээлдүүлэгчийн инженерт шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх орчныг бий болгоно.
- d) ЭКСИМ банк нь Төсөл дууссаны дараа хөрөнгийн чанар, эдэлгээ, Зээлдэгч улсад болон Энэтхэгийн эдийн засагт үзүүлэх цэвэр экспорт/ач холбогдол, төслийн үр ашгийг үнэлэх зорилгоор төслийн үнэлгээг өөрөө болон бие даасан агентлагаар дамжуулан хийж болно. Үнэлгээний судалгаа нь төслийн хамаарал, үр дүнтэй байдал, үр ашиг, хөгжлийн хэтийн үр нөлөө, тогтвортой байдлыг хамарна. Үүний зардлыг Зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ.
- e) Зээлдэгч нь Зээлийн хүчинтэй хугацаанд зээлдэгч улсад байрлах төсөл хэрэгжүүлэх газарт нэвтрэх зөвшөөрлийг ЭКСИМ банк/ Энэтхэг Улсын Засгийн газрын төлөөлөлд олгоно.

## K. Дефолтын нөхцөл байдал:

K.1 Энэхүү заалтын зорилгоор дараах тохиолдлуудыг зөрчилд тооцно. Үүнд:

- (a) Зээлийн Хэлэлцээрийн дагуу Зээлдэгч ЭКСИМ банканд төлбөл зохих төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол;
- (b) Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээсэн бусад үүргээ Зээлдэгч даган биелүүлж чадаагүй бол;
- (c) Зээлдэгчээс ЭКСИМ банканд гарган өгсөн аливаа мэдээлэл, тайлбар нь бүрэн бус буюу алдаатай бол;
- (d) Зээлдэгч ямарваа бусад гадаад өрийг хугацаанд нь үл

Монгол Улсын Сайнмийн яам  
ТАРХСНЫ ОРЧУУЛГА МЭДЛЭЛ

Усаг /Signature/ .....

2021 оны 1 сарын 6-ны 6  
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

төлсөн зөрчил гаргасан, эсхүл Зээлдэгч болон түүний агентлагын гадаад өрийг төлөхөд хориг, хязгаарлалт тавигдах мөн өрийг төлөх хугацаа нь болсон, эсхүл Зээлдэгчийн улс Энэтхэг Улстай төрийн таатай бус нөхцөл байдал үүссэн бол;

- (e) Зээлийн хэлэлцээрийн дагуу хүлээсэн төлбөр төлөх үүргээ биелүүлэх зорилгоор Зээлдэгч гадаад мөнгөн шилжүүлэг хийхэд Зээлдэгчийн улсын хууль тогтоомжоор аливаа хязгаарлалт тогтоосон.

K.2 Хэрэв Дефолтод орох тохиолдол илрэн, энэ тухай ЭКСИМ банк Зээлдэгчид мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор түүнийг засаж запруулах аливаа арга хэмжээ аваагүй бол ЭКСИМ Банк Зээлдэгчид дараах мэдэгдлийг бичгээр хүргүүлнэ. Үүнд:

- (a) Зээлдэгчийн Зээлийн хөрөнгийг ашиглах эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлэх ба тийнхүү түдгэлзүүлэх болсон нөхцөл байдал ЭКСИМ банкны шаардлагыг хангахуйц хэмжээнд арилах хүртэл Зээлийн хөрөнгийг түдгэлзүүлнэ. Дээрх нөхцөл байдал арилсан тохиолдолд ЭКСИМ банк Зээлдэгчийн Зээлийн хөрөнгийг ашиглах эрхийг сэргээснийг Зээлдэгчид мэдэгдэнэ;
- (b) Зээлийн ашиглагдаагүй хэсэг болон ЭКСИМ банкнаас зээлдэгчид олгосон бусад зээлийг хүчингүй болгож, улмаар уг зээлийг цуцална;
- (c) ЭКСИМ банкнаас Зээлдэгчид шинээр болон нэмэлт санхүүжилт олгохгүй;
- (d) Төслийн дансыг царцаах болон энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Зээлдэгчийн хүлээсэн төлбөрийн үүрэг гүйцэтгүүлэх зорилгоор эх үүсвэрийг ашиглана;
- (e) Тухайн тохиолдоос хамааран бүх Урьдчилгаа, эсхүл Зээлийн төлөгдөөгүй үндсэн дүн, түүнчлэн бодогдсон хүү болон ЭКСИМ банканд төлөх ёстой бусад төлбөрийг Зээлдэгч /Зээлийн Хэлэлцээртэй зөрчилдсөн тохиолдол үсэхийг үл харгалзан/ ямар нэг мэдэгдэл, шаардлагагүйгээр ЭКСИМ банканд шууд төлнө. Зээлдэгч нь дээр дурдсан мэдэгдэл, шаардлагад татгалзах эрхээ түдгэлзүүлнэ.

K.3 Дефолтод орсон тохиолдол үүссэнтэй холбоотойгоор Зээлдэгчийн хөрөнгийг битүүмжлэх, Зээлийн хэлэлцээрийн дагуу төлөх хугацаа нь болсон төлбөрийг хураахтай холбоотойгоор ЭКСИМ банкнаас гарсан бүх зардлыг Зээлдэгч төлөх ба тийнхүү төлөх хүртэл Зээлийн Хэлэлцээрт заасан хувиар анх тооцоогоос гадна Хүүгийн хэмжээгээр хүү бодогдоно.

K.4 Дээр дурдсан Дефолтод орсон тохиолдуудтай холбоотойгоор түдгэлзүүлэх, цуцлах, шаардах зэрэг арга хэмжээ авахаас үл хамааран Зээлийн хэлэлцээрийн бүх заалт Зээлдэгчийн ЭКСИМ банканд төлбөл зохих төлбөр төлөгдөөгүй байх хугацаанд бүрэн хүчин төгөлдөр үйлчилнэ. Түүнчлэн Зээлдэгч нь Зээлийн Хэлэлцээрээр хүлээсэн үүргээс ангид, дээр дурдсанчлан Зээлийн хөрөнгийг ашиглахыг түдгэлзүүлэх, зээлийн ашиглагдаагүй хэсгийг цуцлах зэргээс шалтгаалан Худалдагч, эсхүл Худалдан авагчийн зүгээс ЭКСИМ банкны эсрэг авсан аливаа арга хэмжээнээс учрах /шууд буюу шууд бус/ хохирлыг ЭКСИМ Банканд нөхөн төлнө.

#### L. Өрийн нотолгоо

ЭКСИМ банк өөрийн ердийн журмын дагуу Зээлдэгчийн нэр дээр, ЭКСИМ банкнаас тухай бүр зээлж буй дүн, ЭКСИМ банканд эргүүлэн төлөх ёстай мөнгөн дүн болон төлбөрийн түүх, хүлээн авсан мөнгөн дүнг хянах зээлийн данс, түүнчлэн төлөх хүүгийн хэмжээ ба Зээлийн хэлэлцээрийн дагуу төлөгдөх бусад мөнгөн дүн, хүүгийн төлбөрт хүлээн авсан мөнгөний хэмжээ зэргийг хянах хүүгийн дансыг нээн ажиллуулна.

Зээлийн Хэлэлцээртэй холбоотойгоор хийгдэх аливаа үйл ажиллагааны хувьд дээр дурдсан дансанд хийгдсэн гүйлгээ зэрэг нь Зээлдэгчийн хүлээх хариуцлагын хангалттай нотолгоо болно.

#### M. Татгалзал:

Дефолтод орсон тохиолдол гарсан үед Зээлийн Хэлэлцээр болон бусад гэрээ, эсхүл тэдгээрийн дагуу байгуулагдсан баримт бичгүүдийн дагуу ЭКСИМ банк эдлэх эрх, мэдлээ хэрэгжүүлэсгүй, эсхүл зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй буюу хойшлуулсан нь тэдгээр эрх мэдэл, боломжийг сулруулах буюу түүнээс татгалзаж буйг илтгэхгүй хийгээд Зээлдэгч хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээсээ татгалзах шалтгаан болохгүй ба мөн зөрчлийг хүлээн зөвшөөрч буй мэтээр ойлгохгүй. Тэрчлэн аливаа зөрчил илэрсэн үед ЭКСИМ банкны үйлдэл, эс үйлдэл нь, эсхүл аливаа зөрчилтэй эвлэрэх зэрэг нь бусад зөрчлийн үед ЭКСИМ банкны эдлэх эрх, мэдэл, зөрчлийг арилгах арга хэмжээ авахад нелөөлөхгүй. Зээлийн Хэлэлцээрт тусгагдсан эрх, зөрчлийг арилгах арга зам зэрэг нь нэгэн цогц бөгөөд үүнд ямарваа нэг үндэслэлээр ЭКСИМ банканд олгогдсон эрх хэмжээ мөн багтана.

#### N. Эрх шилжүүлэх:

ЭКСИМ банк нь Зээлийн хэлэлцээрийн дагуу өөрт олгогдсон эрх, хүртэх үр ашгийг хэдийд ч Энэтхэг Улсын дотор, эсхүл түүний гадна буй аливаа этгээдэд дамжуулах, тараан өгөх, эсхүл хэсэгчлэн эдлэх боломж олгох эрхтэй байна. Харин Зээлдэгч Зээлийн Хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүргээ шилжүүлэх эрхгүй байна.

Монгол Улсын Сангийн дэл  
— СНЫГ ОРЧУУЛГАА —

— Sign /Signature/ ...  
Х.Онхоны I. сарын б' өдөр  
Х.Санбаатар хот

**O. ЭКСИМ банкны баталгаажуулалт:**

Зээлийн хэлэлцээрийн аливаа заалттай холбоотойгоор ЭКСИМ банк хүүгийн ханш, эсхүл Зээлдэгчийн төлөх мөнгөн дүнг батлах буюу тодорхойлох, эсхүл ямарваа асуудлаар саналаа илэрхийлэх боломжтой бөгөөд уг баталгаажуулалт тодорхойлолт болон санал зэргийн эсрэг сөрөг мэдэгдэл гараагүй тохиолдолд Зээлдэгчийн хувьд заавал дагаж мөрдөх эцсийн шийдвэр байна.

**P. Хэсэгчлэн хүчингүй болох:**

Хэрэв Зээлийн хэлэлцээрийн аль нэг заалт ямарваа нэг хууль, тогтоомжийн дагуу хууль бус, хүчингүй, эсхүл хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Хэлэлцээрийн бусад заалтууд аливаа бусад хуулийн харьяаллын /хууль тогтоомжийн/ дагуу хууль ёсны, хүчин төгөлдөр, хэвээр байна.

**Q. Баримт бичгийн хэл:**

Зээлийн хэлэлцээрийн хүрээнд холбогдох бүх баримт бичгийг Англи хэл дээр үйлдэнэ.

**R. Хууль:**

Энэхүү Зээлийн Хэлэлцээрийг Энэтхэг Улсын хуулийн дагуу тайлбарлаж зохицуулна.

**S. Арбитр:**

- S.1 Энэхүү Хэлэлцээрээс үүдэн талуудын хооронд үүсэх аливаа маргааныг одоо мөрдөж буй IIAC (Арбитрын ажиллагаа) журмын дагуу Энэтхэгийн Олон улсын арбитрын төвөөс (IIAC) удирддаг арбитрын шүүхээр шийдвэрлэнэ. Шүүх турван арбитрчаас бүрдэх бөгөөд арбитраас гаргасан шийдвэрийг талууд заавал биелүүлнэ. Арбитрын хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах газар нь Энэтхэг Улсын Шинэ Дэли хот байх бөгөөд шүүх үйл ажиллагааны хэл нь англи хэл байна.
- S.2 Зээлийн Хэлэлцээр болон түүний дагуу байгуулагдсан бусад баримт бичгээс үүдэх аливаа арбитрын хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах газар нь Шинэ Дэли хот байхыг одоо буюу цаашид эсэргүүцэхээс Зээлдэгч ямарваа нөхцөл болзолгүйгээр, бүрмөсөн татгалзана. Түүнчлэн Зээлдэгч арбитрын шүүхээс түүний эсрэг гаргасан шийдвэр нь үүссэн маргааны болоод түүнийг төлж барагдуулбал зохих хохирлын хэмжээг тогтоосон нотолгоо болох бөгөөд тэрхүү шийдвэрийг түүний баталгаажсан үнэн зөв хуулбарыг үндэслэн Зээлдэгчийн улс гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх тухай хууль тогтоомжийн дагуу мөн Гадаадын Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1958 оны Нью-Йоркийн конвенцийн дагуу Зээлдэгч биелүүлж гүйцэтгэхийг зөвшөөрөв.
- S.3 Зээлдэгч нь Зээлийн Хэлэлцээр болон түүний дагуу байгуулагдсан бүх баримт бичгүүдтэй холбоотойгоор гарсан аливаа арбитрын шүүхийн

Монгол Улсын Сийлтийн зам  
ДАН ЕСНЫ ОРЧУУЛГА МТ

.....  
.....  
.....

2021 оны 1 сарын 6 аад

Улаанбаатар хот

шийдвэр ёсоор зөрчигдсөн эрхийг хамгаалах аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шийдвэрийг дагах, биелүүлэхийг ерөнхий байдлаар зөвшөөрнө.

- S.4 Зээлдэгч буюу түүний өмч, хөрөнгө, орлогын алин боловч шүүхэд дуудагдах, хураагдах /шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхээс өмнө буюу шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлж буй аль ч үед/, нөхөн төлөх, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх буюу эсхүл бүрэн эрхт байдлын буюу бусад үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хамгаалагдах халдашгүй дархан байдал, онцгой эрх олгогдох, түүнчлэн аливаа хуулийн харьяаллын дагуу Зээлдэгч, түүний хөрөнгө, орлогод халдашгүй, онцгой эрх олгогдсон тохиолдолд Зээлдэгч нь Зээлийн Хэлэлцээрээр хүлээсэн үүргийнхээ дагуу тухайн хуулийн харьяалал, түүний хууль тогтоомжоор зөвшөөрөгдөх хэмжээнд тэдгээр эрхээс бүрмөсөн татгалзахыг зөвшөөрөв.

**T. Мэдэгдэл:**

Зээлийн Хэлэлцээртэй холбогдуулан хийх аливаа мэдэгдэл, хүсэлт, шаардлагыг агаарын шуудан, цахилгаан, баталгаажуулсан СВИФТ КОД, эсхүл факсаар илгээхдээ зохих ёсоор хүргүүлэх буюу мэдээлнэ. Эдгээр мэдэгдэл, хүсэлт, шаардлагыг хүргүүлэхдээ хүлээн авагч талын дор заасан хаяг, эсхүл бичгээр мэдэгдсэн бусад хаягаар илгээсэн бол уг мэдэгдэл, хүсэлт, шаардлагыг зохих ёсоор хүргүүлсэн буюу мэдээлсэн гэж үзнэ. Хэрэв аливаа мэдэгдэл, хүсэлт, шаардлагыг цахилгаанаар, эсхүл факсаар илгээсэн бол илгээгч тал нь тэдгээрийн баталгаажуулсан хувийг шуудангаар зохих хугацааны дотор хүргүүлнэ.

**ЗЭЭЛДЭГЧ:**

Монгол Улсын Засгийн Газар

Хариуцах байгууллага:

Утасны дугаар:

Факс:

СВИФТ:

**ЭКСИМ БАНК:**

Энэтхэг Улсын Экспорт-Импортын Банк  
Оффисын блок, цамхаг 1, 7 давхар, хажуугийн  
тойруу, Зүүн Кидвай Нагар, Шинэ Дели-110023

Хариуцах байгууллага: "Эл Өү Си" Групп

Утас: (91-11) 24607700

Факс: (91-11) 20815029

Свифт код: EIBIINBB

Цахим шууданг: eximloc@eximbankindia.in

Монгол Улсын Сангийн яам  
СНЫ ОРЧУУЛГАА

2022 оны 1 сарын 6 өдөр

Төгвөнбаятар хот

Ministry of Finance of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

**ҮҮНИЙГ НӨТЛӨН**, талуудыг төлөөлж эрх олгогдсон эрх бүхий этгээдүүд дор дурдсан өдөр энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав. Хэлэлцээрийг хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

2025 оны ... дүгээр сарын ... -ны өдөр  
гарын үсэг зурав.

**ЭНЭТХЭГ УЛСЫН**

**ЭКСПОРТ-ИМПОРТЫН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ**

2025 оны ... дүгээр сарын ... -ны өдөр  
гарын үсэг зурав.

## ХАВСРАЛТ-И

### Гэрээ батлах маягт

(Монгол Улсын Засгийн газрын хэвлэмэл хуудас дээр үйлдэнэ)

(ЗЭЭЛДЭГЧИЙН НЭР) БОЛОН ЭКСИМ БАНК ХООРОНД  
.... ОНЫ ...-Р САРЫН ... ӨДӨР БАЙГУУЛСАН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ДАГУУ  
САНХҮҮЖИГДЭХ ЭКСПОРТЫН ГЭРЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА.

1. Хэлэлцээрийн №. огноо :
2. Импортлогчийн нэр, хаяг :
3. Экспортлогчийн нэр, хаяг :
4. Хэлэлцээрийн мөнгөн тэмдэгт : ам.доллар
5. Хэлэлцээрийн үнэ : ам.доллар
6. Хойшлуулсан кредит :
7. Барааны тодорхойлолт :
8. Энэтхэг Улсаас нийлүүлэх барааны үнэ : ам.доллар
9. Бараа нийлүүлэлтийн хугацаа :
10. Тээвэрлэлтийн өмнөх шалгалт  
хийх байгууллага :
11. ТМЗ :

(Эрх бүхий этгээд(үүд)-ийн нэр, гарын үсэг)

ХАВСРАЛТ-II

## Зээлдэгчийн хуулчийн хууль зүйн дүгнэлтийн загвар

(Монгол улсын Засгийн газрын Хуулийн байгууллагын хэвлэмэл хуудас дээр үйлдэнэ)

Дугаар:

ОГНОО:

Энэтхэг Улсын  
Экспорт-Импортын Банк  
Оффисын блок, цамхаг 1,  
7 давхар, хажуугийн тойруу,  
Зүүн Кидвай Нагар,  
Шинэ Дели-110023

Монгол улсын Засгийн газарт олгох .....-нд  
Байгуулсан ..... зээлийн тухай

## Хүндэт Ноён/Хатагтай.....

1. \_\_\_\_\_ Засгийн газар /“Засгийн газар”/-ын  
яамны Хуулийн зөвлөх /Нэр/ миний бие .....-ын  
Засгийн газар, Энэтхэг Улсын Экспорт-Импортын Банк /“ЭКСИМ Банк”/-ны  
хооронд ...ны өдөр байгуулсан, ЭКСИМ Банкнаас .....-ын Засгийн  
газарт .....ам.долларын өртөг бүхий зээл /“Зээл”/  
олгох тухай Зээлийн хэлэлцээртэй танилцаа.

Үүнтэй холбогдуулан миний бие Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомж, тогтоол, шүүхийн шийдвэрүүд, дүрэм журмууд болон дор дурдсан хууль зүйн дүгнэлтийг гаргахад чухал шаардлагатай буюу хамааралтай хэмээн үзсэн гэрээ, хэлэлцээр, баримт бичгүүдийг судлан үзэв.

Дээр дурдсаны дагуу миний бие дараах дүгнэлтийг хийв. Үүнд:

- (a) Засгийн газар нь Хэлэлцээр байгуулах, Хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна;

(b) Монгол Улсын Засгийн газрын \_\_\_\_\_ яамыг төлөөлж Засгийн газрын нэрийн өмнөөс Хэлэлцээрт гарын үсэг зурсан ноён \_\_\_\_\_ болон ноён \_\_\_\_\_ нь (нар нь) Хэлэлцээр болон түүнтэй холбоотой бүх баримт бичгийг Засгийн газрын нэрийн өмнөөс байгуулах бүрэн эрх олгогдсон эрх бүхий этгээд(үүд) байна;

(c) Хэлэлцээр байгуулахад шаардлагатай зөвшөөрөл болон бусад журмын

шаардлагыг Засгийн газрын зохих эрх бүхий этгээд/байгууллагууд хийж гүйцэтгэсэн байна;

- (d) Иймд уг Хэлэлцээрийг зохих ёсоор зөвшөөрч, байгуулж, гарын үсэг зурж, хүргүүлсэн/ Засгийн газрыг төлөөлж, гарын үсэг зурж, хүргүүлж болох бөгөөд Хэлэлцээрт заасан бүх нөхцөл, болзлын хувьд Засгийн газарт хүчин төгөлдөр байх бөгөөд заавал биелүүлэх үүрэг хүлээх болно.

Энэхүү дүгнэлтийг Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой холбогдох Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд гаргасан бөгөөд өөр бусад хуулийн харьяалал, түүний хууль тогтоомжийн талаар дүгнэлт тайлбар хийгээгүй болно.

Хүндэтгэсэн,

(Хуулийн зөвлөхийн нэр, гарын үсэг)

\* Тохирохгүй хэсгүүдийг хасна уу.

Монгол Улсын Сангийн яан  
ЧАН РСНЫ ОРЧУУЛГА М

.....  
2015 оны 1.. сарын 6 өдөр  
Улаанбаатар хот

## ХАВСРАЛТ-III

### Төлбөрийн зөвшөөрлийн маягт ТӨЛБӨР БАТАЛГААЖУУЛАГЧИЙН ТӨСӨЛ

(Монгол Улсын Засгийн газрын хэвлэмэл хуудас дээр үйлдэнэ)

Энэтхэг Улсын  
Экспорт-Импортын Банк  
Оффисын блок, цамхаг 1,  
7 давхар, хажуугийн тойруу,  
Зүүн Кидвай Нагар,  
Шинэ Дели-110023

Эрхэм хүндэт Ноёдоо,

\_\_\_\_\_ -ний өдөр гарын үсэг зурсан \_\_\_\_\_ ам.долларын  
Зээл олгох тухай Зээлийн хэлэлцээрийн  
хүрээнд \_\_\_\_\_ (Худалдагч) болон  
\_\_\_\_\_ (Худалдан авагч) нарын хооронд байгуулсан  
\_\_\_\_\_ ам.долларын өртөг бүхий гэрээний тухай

Худалдан авагчийн зохих ёсоор баталгаажуулсан \*дээрх гэрээний дагуу  
урьдчилгаа төлөхтэй/\*дээрх гэрээний дагуу Худалдагчаас Худалдан авагчид  
үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой/ үнэлгээний зардлын  
\_\_\_\_\_ ам.долларын \_\_\_\_\_ нэхэмжлэхийг Худалдагчаас бидэнд  
иরүүлснийг мэдээлж байна.

Иймд бид нэхэмжлэхэд дурдсан \_\_\_\_\_ ам.долларыг Худалдагчийн  
заасан дансанд Худалдагчаас ЭКСИМ банканд өгсөн төлбөрийн зааврын дагуу  
телөх эрхийг ЭКСИМ банканд бүрэн олгож байна. ЭКСИМ банкнаас  
Худалдагчид төлсөн дүнг Зээлийн хөрөнгөөс бидэнд олгож буй Урьдчилгаа  
хэмээн тооцох бөгөөд ЭКСИМ банкнаас уг төлбөрийг хийсэн/Мумбайгаас уг  
төлбөрийг шилжүүлсэн огноог Урьдчилгаа хийсэн огноо хэмээн тооцно.

Дээр дурдсаны дагуу урьдчилгааг төлсөн даруйдаа төлбөр хийсэн огноо,  
төлбөрийн дүнгийн талаар бидэнд мэдэгдэхийг ЭКСИМ банкнаас хүсье.

Хүндэтгэсэн,

\* Тохиорхгүй хэсгүүдийг хасна уу.  
(Эрх бүхий этгээд(үүд)-ийн нэр, гарын үсэг)

## ХАВСРАЛТ-IV

### Эргэн төлөлтийн хуваарь

Зээлдэгч нь ЭКСИМ Банкны мэдэгсний дагуу аливаа өөрчлөлтийг хийх боломжтой бөгөөд энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 (тав) жилийн хугацаанаас хойших хугацаанд 31 (Гучин нэг) удаа хагас жил бүр тэнцүү хуваартьайгаар зээлээ төлнө.

**Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болох огноог 2025 оны 1-р сарын 31-ний өдөр гэж тооцсон зээлийн эргэн төлөлтийн хуваарийг доор үзүүлэв.**

Д/Д	Хүчин төгөлдөр болсон хугацаанаас эргэн төлөгдөх хугацаа	Эргэн төлөлтийн дүн	Эргэн төлөлтийн хувь (%)	Зээлийн үлдэгдэл
1	31.01.2030	22,582,000.00	3.226 %	677,418,000.00
2	31.07.2030	22,582,000.00	3.226 %	654,836,000.00
3	31.01.2031	22,582,000.00	3.226 %	632,254,000.00
4	31.07.2031	22,582,000.00	3.226 %	609,672,000.00
5	31.01.2032	22,582,000.00	3.226 %	587,090,000.00
6	31.07.2032	22,582,000.00	3.226 %	564,508,000.00
7	31.01.2033	22,582,000.00	3.226 %	541,926,000.00
8	31.07.2033	22,582,000.00	3.226 %	519,344,000.00
9	31.01.2034	22,582,000.00	3.226 %	496,762,000.00
10	31.07.2034	22,582,000.00	3.226 %	474,180,000.00
11	31.01.2035	22,582,000.00	3.226 %	451,598,000.00
12	31.07.2035	22,582,000.00	3.226 %	429,016,000.00

13	31.01.2036	22,582,000.00	3.226 %	406,434,000.00
14	31.07.2036	22,582,000.00	3.226 %	383,852,000.00
15	31.01.2037	22,582,000.00	3.226 %	361,270,000.00
16	31.07.2037	22,582,000.00	3.226 %	338,688,000.00
17	31.01.2038	22,582,000.00	3.226 %	316,106,000.00
18	31.07.2038	22,582,000.00	3.226 %	293,524,000.00
19	31.01.2039	22,582,000.00	3.226 %	270,942,000.00
20	31.07.2039	22,582,000.00	3.226 %	248,360,000.00
21	31.01.2040	22,582,000.00	3.226 %	225,778,000.00
22	31.07.2040	22,582,000.00	3.226 %	203,196,000.00
23	31.01.2041	22,582,000.00	3.226 %	180,614,000.00
24	31.07.2041	22,582,000.00	3.226 %	158,032,000.00
25	31.01.2042	22,582,000.00	3.226 %	135,450,000.00
26	31.07.2042	22,582,000.00	3.226 %	112,868,000.00
27	31.01.2043	22,582,000.00	3.226 %	90,286,000.00
28	31.07.2043	22,582,000.00	3.226 %	67,704,000.00
29	31.01.2044	22,582,000.00	3.226 %	45,122,000.00
30	31.07.2044	22,582,000.00	3.226 %	22,540,000.00
31	31.01.2045	22,540,000.00	3.220 %	-
	<b>Total</b>	<b>700,000,000.00</b>	<b>100.00%</b>	

Зээлдэгч нь ЭКСИМ Банкны мэдэгсний дагуу аливаа өөрчлөлтийг хийх боломжтой бөгөөд энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 (тав) жилийн хугацаанаас хойших хугацаанд 31 (Гучин нэг) удаа хагас жил бүр тэнцүү хуваартьгаар зээлээ төлнө.

ЖИЧ: Зээлийн Хэлэлцээр хүчин төгөлдөр болмогц ЭКСИМ банк зээлийн эргэн төлөлтийн хуваарийг зээлдэгчид мэдэгдэх болно.

Монгол Улсын Сайдын Язгуулжны СРЧУУЛТ

.../Signature/ ...

2021 оны 11 сарын 6-ны  
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia  
OFFICIAL TRANSLATION

## ХАВСРАЛТ-V

### Гарын үсэг зурах эрх олгох маягтын загвар (Монгол Улсын Засгийн газрын хэвлэмэл хуудас дээр үйлдэнэ)

Дугаар:

Огноо:

Энэтхэг Улсын  
Экспорт-Импортын Банк  
Оффисын блок, цамхаг 1,  
7 давхар, хажуугийн тойруу,  
Зүүн Кидвай Нагар,  
Шинэ Дели-110023

**ЭКСИМ банкнаас Монгол улсын Засгийн газарт олгох .....-нд  
байгуулсан ..... ам.долларын Зээлийн Хэлэлцээр**

овогтой \_\_\_\_\_ миний бие (албан тушаал)  
\_\_\_\_\_ ("Зээлдэгч") дараах албан тушаалтнуудад хамтран/  
хэсэгчлэн\* Төлбөр хийх зөвшөөрөл олгох болон бусад баримт бичигт гарын  
үсэг зурах, Хэлэлцээрийн хэрэгжилттэй холбоотойгоор Зээлдэгчийг төлөөлөх  
эрхийг олгож байгаа үүгээр баталгаажуулж байна. Үүнд:

Нэр	Албан тушаал	Баталгаат гарын үсэг

\* Тохиорхгүй хэсгүүдийг хасна уу.

(Эрх бүхий этгээд(үүд)-ийн  
нэр, гарын үсэг)

Тамга